



УЛААНБААТАР  
ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

ТОГТООЛ

1987 оны 2 сарын 16 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

Хүүхдийн спорт, уран бүтээлийн төвд ажиллах дугуйлан, багш нарын орон тооны тухай

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1986 оны 341 дүгээр тогтоол, Хөдөлмөр, нийгэм хангамжийн улсын хорооны мөн оны 337 дугаар тогтоолыг үндэслэн Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Хүүхдийн спорт, уран бүтээлийн төвийн дүрэм, тус төвд ажиллах дугуйлан, багш нарын орон тоог хавсралтаар баталсугай.

2. Хүүхдийн спорт, уран бүтээлийн төвд ажиллах багш нарын дугуйлангийн хичээлийн цагийн норм, цалинг БНМАУ-ын Хөдөлмөр, нийгэм хангамжийн улсын хороо, МУЭ-ийн Төв Зөвлөлийн "Сургуулиас гадуур хүмүүжил олгох байгууллагын дугуйлангийн багш нарын цалин олгох сургалтын ажлын цагийн норм тогтоох тухай" 1985 оны 114/76 дугаар тогтоолын дагуу тогтоож цалинжуулж байхыг Ардын боловсролын удирдах газар /н. Батмагнай/-т зөвшөөрсүгэй. *Хотын АДХГЗ-ийн 1989 оны 16.1 дүгээр тогтоол*

~~3. Хүүхдийн спорт, уран бүтээлийн төвийн 1987 оны орон тоо, төсвийг хянан бүртгэж баталж өгөхийг санхүүгийн хэлтэс /н. Эрдэмбат/-т даалгасугай.~~

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулж Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны 1986 оны 222 дугаар тогтоолыг 3, 5 дугаар зүйл, 1, 2 цугаар хавсралтыг хүчингүй болгосугай.



УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА

*[Signature]* МОНХМАРТАЙ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ХАРИУЦ-  
ЛАГАТАЙ НАРИЙН БИЧИГЭЛЭЙ ДАРГА

*[Signature]* Ч.ЖАМБАЛ

Улаанбаатар хотын АИХ-ын гүйцэтгэх захиргааны 1937 оны дүгээр тогтоолоор батлав.

ХҮҮХДИЙН СПОРТ, УРАН БҮТЭЭЛИЙН ТӨВИЙН ДҮРЭМ

Нэг. Ерөнхий зүйл

1. Хуухдийн спорт, уран бүтээлийн төв нь ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг чөлөөт цагаар тэдний авьяас сонирхлын дагуу спорт, уран бүтээлийн дугуйлангуудад хамааруулан бие бялдар, оюун ухааны өв тэтгэ хумуужилтэй, сахилга, дэг журамтай иргэд болгон төлөвшүүлж, тэдний техник сэтгэлгээ, зохион бүтээх болон урлаг, спортын авьяасыг хөгжүүлж, хөдөлмөрийн дадлага олгох зорилготой сургуулийн дагуурх хуухдийн хумуужлийн байгууллага болно.

2. Хуухдийн спорт, уран бүтээлийн төв нь үйл ажиллагаандаа нам, засгаас өсвөр үеийг халамжлан хумуужуулах талаар гаргасан БНМАУ-ын хууль тогтоомж, хот, районн АИХ-ын гүйцэтгэх захиргаа, Ардын боловсролын байгууллагын тогтоол, шийдвэрийг удирдлага болгоно.

3. Хуухдийн спорт, уран бүтээлийн төв нь хотын Ардын боловсролын удирдах газрын шууд удирдлагын дор районы ардын боловсролын хэлтсийн харьяанд ажиллана.

4. Хуухдийн спорт, уран бүтээлийн төвийг сурган хумуужуулах ухааны мэдлэгтэй, ажлын арга туршлагатай, дээд боловсролтой эрхлэгч арга зүйч удирдах бөгөөд эрхлэгч-арга зүйчийг хотын ардын боловсролын удирдах газрын даргын тушаалаар томилно.

5. Төвийн эрхлэгч-арга зүйч нь эрх хэмжээнийхээ асуудлаар тушаал гаргаж боловсон хүчнийг ажилд томилох, аж ахуй, санхүү, хөдөлмөр хамгаалал, байгууллагын хөдөлмөрийн сахилга, дэг журмыг хариуцан дугуйлан секцүүдийг удирдан зохион байгуулж, багш нарын төлөвлөгөө, конспект, бусад баримт бичгийг баталж мөрдүүлэн ажиллана.

6. Хуухдийн спорт, уран бүтээлийн төв нь тогтоосон журмыг дагуу хийсэн тэмцэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

7. Хуухдийн спорт, уран бүтээлийн павильоны тавилга, тоног төхөөрөмж, сургалтын материал, хэрэгслүүд нь төвийн өмч хөрөнгө

байх бөгөөд цалин, сургалтын болон захиргаа, аж ахуйн зардлыг хот, районы төсвөөс, барилгуудын ашиглалтын зардал /гэрэл, халаалт, талбайн хөлс, цэвэр бохир усны үнэ, барилгын засвартай холбогдолтой зардлууд/-ыг орон сууц нийгмийн аж ахуйн байгууллага харууцан санхүүжүүлнэ.

8. Хүүхдийн спорт, уран бүтээлийн төв хуулийн этгээд мөн бөгөөд үйлдвэр, албан байгууллага, газар, иргэдтэй гэрээ хэлцэл хийж, төсвийн гадуурх данстай байна.

Төсвийн гадуурх дансны орлогыг зохих хууль дүрмийн дагуу зарцуулна.

Хоёр. Хүүхдийн спорт, уран бүтээлийн төвийн зохион байгуулалт, ажиллах журам

1. Хүүхдийн спорт, уран бүтээлийн төвд спорт, уран бүтээлийн навильон харъяалагцан ажиллана.

2. Дугуйлан, секцүүд нь Улаанбаатар хотын А.ДХ-ын гүйцэтгэх захиргаанаас тогтоосон цагийн хуваарийг баримтлан хичээл хүмүүжлийн ажил зохино.

3. Хүүхдийн спорт, уран бүтээлийн төвийн эрхлэгч-арга зүйч, дугуйлангийн багш нарын цагийн норм, цалинг сургуулиас гадуур хүмүүжил олгох байгууллагын дугуйлангийн багш нарын цалин олгох, сургалтын ажлын цагийн норм тогтоох тухай БНМАУ-ын Хөдөлмөр, нийгэм хангамжийн улсын хэрс, МУЭ-ийн Төв Зөвлөлийн 1985 оны 114/76 дугаар тогтоолын дагуу олгоно.

4. Хүүхдийн спорт, уран бүтээлийн төвөөс зохиох дугуйлан секцүүдэд нь орон сууцны III-IV хороололд байрладаг ерөнхий боловсролын сургуулиудыг хамаарах боловч суралцахыг хүссэн бусад ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдийг суралцуулах орон тоо байвал нэгэн адил авч тэдний сонирхсон дугуйлан секцүүдэд сонгон авч суралцуулна.

а/спорт, навильоны гүйцэтгэх үүрэг

1. Хүүхдийн спортын навильон нь өсвөрийн хүүхдүүдийг коммунист хүмүүжлийн салшгүй хэсэг болсон биеийн тамир, спортоор

хичээллүүлж, бие бялдрыг чийрэгжүүлэн, тэдний хөдөлмөрт болон эх орноо батлан хамгаалахад бэлтгэхэд туслана.

2. Спорт навильоноос явуулж байгаа дугуйлан, секцийн чиглэлээр ерөнхий боловсролын сургуулийн хамтлаг, сонгон суралцах бүлэг, спортын өдөр өнжүүлэх бүлэг, биеийн тамирын багш нарт мэргэжлийн зөвлөлгөө өгч байна.

3. Дугуйлан, секцэнд хамаарагдах тойргийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд зохиох биеийн тамирын хүмүүжлийн ажлын талаар тэдгээр сургууль, биеийн тамир спортын байгууллагуудтай байнга холбоотой ажиллана.

4. Спорт навильоноос дугуйлан секцэнд оролцож байгаа пионер сурагчдын спортын уран чадвар, арга техникийг дээшлүүлэх зорилгоор уралдаан тэмцээн, үзүүлэх тоглолтыг зохион байгуулна.

5. Ерөнхий боловсролын сургуулийн дунд биеийн тамир спортыг сурталчлах ажлыг тодорхой төлөвлөгөөний үндсэн дээр явуулна.

6. Хамран үйлчлэх сургуулиудын тэмцээнээс шалгарсан пионер сурагчдыг дугуйлан, секцийн чиглэлээр улс, хот, район чиглэлтэй уралдаан тэмцээнд оролцуулж бэлтгэлийг хангана.

7. Биеийн тамир спортын талаар гарсан тэргүүн туршлагыг судлан бүтээлчээр нэвтрүүлнэ.

#### 6/Уран бүтээлийн навильон гүйцэтгэх үүрэг

1. Уран бүтээлийн навильон нь пионер сурагчдыг нам, ард түмнийхээ хувьсгалч баатарлаг, хөдөлмөрч уламжлал, төрөлх эх оронч үзлээр хүмүүжүүлэх, тэдэнд гоо зүй болон хөдөлмөрийн дацлага олгох, оюуны сэтгэлгээг хөгжүүлэхэд ажлаа чиглүүднэ.

2. Пионер сурагчдыг авьяас сонирхлын дагуу уран сайхан, уран бүтээлийн дугуйлан секцүүдэд элсүүлж уран зураг, баримал, наамал, хатгамал, оёдол, хөгжмийн зэмсэг эзэмшүүлж авьяасыг хөгжүүлэх.

3. Нэхмэл, хатгамал урлах, гар машинаар эдлэл хийх арга барилыг дугуйлангийн хичээлээр эзэмшүүлэн, загвар зохиох,

бэлэн загварт өөрчлөлт оруулж сайжруулах зэрэг сурагчдын бүтээлч үйл ажиллагааг хөгжүүлэх, мэргэжлээ ухамсартай зөв сонгоход туслана.

4. Улс ардын аж ахуйн түгээмэл мэргэжлийг сурталчилна.

5. Дугуйлангийн пионер сурагчдын бүтээлээр концерт, үдэшлэг, уран бүтээлийн үзэсгэлэн зохион байгуулна.

6. Дугуйлан секцүүдийн хичээлтэлт, урлаг, уран бүтээлийг сайжруулах зорилгоор мэргэжлийн байгууллагуудаас туслалцаа авч урлагийн мастеруудтай уулзалт үдэшлэг зохиож байна.

УЛААНБААТАР ХСТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРГАА

04  
Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэт-  
гэх захиргааны 1987 оны  
дугаар тогтоолын хавсралт № 2

ХҮҮХДИЙН СПОРТ, УРАН БҮТЭЭЛИЙН ТӨВД  
АЖИЛЛАХ ДУГУЙЛАН СЕКЦИ

Нэг. Спортын павильон

1. Үндэсний бөх
2. Чөлөөт бөх, самбо, жудо
3. Спорт тоглоом /гар, сагсан бөмбөг/
4. Гимнастик /уран сайхны, спортын/
5. Шатар, даам
6. Ширээний теннис

Хоёр. Уран бүтээлийн павильон

1. Найрал дуу
2. Бүжиг
3. Фото зураг
4. Сөдол, хатгамал, нэхмэл
5. Хөгжим
6. Уран зураг
7. Кино техник
8. Техник, зохион бүтээх

Бүгд 14 дугуйлан ажиллана.

Улаанбаатар хотын АИХ-ын гүйцэтгэх захиргааны 1987 оны дугаар тогтоолын хавсралт № 3

ХҮҮХДИЙН СПОРТ, УРАН БҮТЭЭЛИЙН  
ТӨВД АЖИЛЛАХ БАГШ НАРЫН ЖАГСААЛТ

№	Дугуйлангийн нэр	хэдэн багш	бүлэг	хамаарах хүүхэд
1.	Үндэсний бөх	I	2	20-30
2.	Чөлөөт, самбо, жудо бөх	I	2	20-30
3.	Спорт тоглоомын багш	I	4	12-24
4.	Гимнастик	I	4	10-15
5.	Шатар, даам	I	3	20-30
6.	Ширээний теннис	I	3	15-20
7.	Найрал дуу	I	3	30-40
8.	Бүжиг	I	2	15-25
9.	Фото зураг	I	4	15-25
10.	Оёдол, хатгамал, нэхмэл	I	3	15-25
11.	Хөгжим	I	3	15-20
12.	Уран зураг	I	3	15-20
13.	Кино техник	I	2	15-25
14.	Техник зохион бүтээх	I	3	15-20
15.	Концертмейстер	I		
	БҮГД	15	41	